

# З

# САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ СУДАЛГАА

Д.Дашням, Х.Нинжбадгар, Д.Хулан, Ц.Батнавч

## ХУРААНГУЙ

Санхүүгийн нэгдэл нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн олон салбарыг хамарсан бүтэц бөгөөд эдийн засгийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлдэг. Санхүүгийн нэгдлийг оновчтой зохицуулах нь зах зээлийн эрсдэлийг бууруулж, зах зээлийн итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Олон улсын санхүүгийн байгууллагууд санхүүгийн нэгдлийг хянах нийтлэг зарчим, аргачлалыг тодорхойлсон бөгөөд улс орнууд эдгээр зарчмуудыг үндэслэн эрх зүйн зохицуулалтын орчноо бүрдүүлж байна. Энэхүү судалгаанд Их Британи, Австрали, Сингапур, Япон, БНСУ зэрэг улсын туршлагыг авч үзсэн бөгөөд харьцуулсан дүн шинжилгээний үр дүнд санхүүгийн нэгдэл нь зах зээлийн үр ашигт эерэгээр нөлөөлөхийн зэрэгцээ хяналт, зохицуулалт сул тохиолдолд системийн эрсдэлийг нэмэгдүүлэх эрсдэлтэй болохыг харуулж байна.

Энэхүү судалгаа нь олон улсын санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалтын эрх зүйн орчны сайн туршлагыг харьцуулан судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжит саналыг боловсруулахад чиглэсэн.

**Түлхүүр үгс:** Санхүүгийн нэгдэл, нэгдлийн хяналт шалгалт, эрсдэлийн удирдлага, санхүүгийн тогтвортой байдал

**JEL ангилал:** G28, G32, K23

<sup>1</sup> СЗХ, ЗЗСХГ, Ахлах референт, dashnyam\_d@frc.mn

<sup>2</sup> СЗХ, ЗЗСХГ, Ахлах мэргэжилтэн, ninjbadgar@frc.mn

<sup>3</sup> СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, khulan@frc.mn

<sup>4</sup> СЗХ, ЗЗСХГ, Мэргэжилтэн, batnavch@frc.mn

# АГУУЛГА >>>

I.	УДИРТГАЛ .....	92
II.	САНХҮҮГИЙН НЭГДЭЛ БА ТҮҮНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОЙЛГОЛТ .....	93
2.1	Санхүүгийн нэгдлийн тодорхойлолт, ангилал .....	93
2.2	Санхүүгийн нэгдлийн үүсэл, хөгжил .....	94
2.3	Хяналт, шалгалтын чиг үүрэг, зорилго .....	96
III.	ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА .....	98
3.1	Олон улсын байгууллагуудын зарчим, зөвлөмж .....	98
3.2	Их Британи Улсын туршлага .....	101
3.3	Австрали Улсын туршлага .....	104
3.4	Азийн орнуудын туршлага (Сингапур Улс, Япон Улс, Өмнөд Солонгос Улс) ...	107
3.4.1	Сингапур Улс .....	107
3.4.2	Япон Улс .....	109
3.4.3	Өмнөд Солонгос Улс .....	110
3.5	Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал .....	115
	ДҮГНЭЛТ, САНАЛ .....	118
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	120

## ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.	Санхүүгийн нэгдлийн үйл ажиллагааг хянах чиглэл .....	98
Хүснэгт 2.	Joint forum–аас гаргасан зарчим .....	99
Хүснэгт 3.	Үндсэн бүтэц (3 тулгуур багана) .....	100
Хүснэгт 4.	Их британи Улсын зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг .....	101
Хүснэгт 5.	Их Британи Улсын санхүүгийн нэгдэл ба бусад санхүүгийн бүлгийн зохицуулалтын журам .....	102
Хүснэгт 6.	Австрали Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг .....	104
Хүснэгт 7.	Австрали Улсын санхүүгийн нэгдлийн /Level–3/ хяналт шалгалтын стандарт, зөвлөмж .....	105
Хүснэгт 8.	Сингапур Улсын Санхүүгийн холдингийн тухай хууль, 2013 .....	108
Хүснэгт 9.	Япон Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг .....	109
Хүснэгт 10.	Солонгос Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг .....	111
Хүснэгт 11.	Солонгос Улсын Санхүүгийн конгломератуудын хяналтын тухай хууль, 2021 .....	112
Хүснэгт 12.	Улс орнуудын харьцуулалт .....	114
Хүснэгт 13.	Монгол Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг .....	116
Зураг 1.	Дэлхийн санхүүгийн зах зээл дэх санхүүгийн нэгдлийн ерөнхий бүтэц .....	94
Зураг 2.	Санхүүгийн нэгдлийн үйл ажиллагааг хянан зохицуулах арга .....	97

## I. УДИРТГАЛ

Санхүүгийн нэгдэл нь үндэстэн дамнасан болон дотоодын гэсэн ерөнхий хэлбэртэй байх бөгөөд банк, даатгал эсхүл хөрөнгө оруулалтын компани давамгайлсан гэж ангилагдаж байна. Санхүүгийн нэгдэл нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн салбарын гол чиглэлүүдийг нэгтгэдэг бөгөөд тэдгээрийн харилцан уялдаа, нэгдлийн үйл ажиллагаа нь улс орны эдийн засгийн хөгжил, санхүүгийн тогтвортой байдалд шийдвэрлэх ач холбогдолтой (OECD, 2021). Санхүүгийн нэгдэлд хяналт тавих оновчтой зохицуулалтын орчин бүрдүүлэх нь зах зээлийн эрсдэлийг бууруулах, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангах, зах зээлийн оролцогчдын итгэлийг нэмэгдүүлэх (FSB, 2022) болон хяналт шалгалтын нэгдсэн бодлого хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой (OECD, 2021).

Олон улсын хэмжээнд санхүүгийн нэгдлийн зохицуулалт нь улс орнуудын эдийн засгийн онцлог, зах зээлийн бүтэц, санхүүгийн тогтолцооны хөгжилтэй уялдан ялгаатай байна (Basel committee on banking supervision, 2020). Гэсэн хэдий ч олон улсын санхүүгийн байгууллагууд, тухайлбал Олон улсын валютын сан (IMF), Дэлхийн банк, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (FSB) зэрэг байгууллагууд санхүүгийн нэгдлийг зохицуулах нийтлэг зарчмуудыг тодорхойлсон байдаг (IMF, 2021). Эдгээр зарчмуудыг үндэслэн улс орнууд санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын арга механизм,

эрх зүйн орчныг бүрдүүлдэг. Энэхүү судалгааны ажил нь Англи, Австрали, Сингапур, Япон, БНСУ зэрэг улсуудын санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын эрх зүйн орчин, олон улсын байгууллагуудаас гаргасан нийтлэг зарчим, зөвлөмжүүд болон Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, санал боловсруулахад чиглэнэ.

Санхүүгийн нэгдлийн хяналт, зохицуулалтын чиглэлээр хийгдсэн судалгааны ажлууд цөөнгүй бөгөөд дэлхий даяар эрсдэлийн мэдрэмжтэй, зарчимд суурилсан нэгдсэн хяналт, нэгтгэсэн тайлагналын тогтолцоо руу шилжиж буй хандлагыг илэрхийлж байна. Van Lelyveld ба Schilder нар (2002) банк, даатгал, үнэт цаасны үйл ажиллагааг нэгтгэсэн нэгдлүүдийн өсөлтөөс үүдэх системийн эрсдэл болон «хэт томоосоо болоод дампуурч болохгүй» (TBTF)-г онцолж, Basel II-ын хоёрдугаар тулгуурт нийцсэн онолын арга зүйг боловсруулсан нь анхны иж бүрэн шинжилгээний нэг болсон бол Fultanegara нар (2024) бүс нутгийн болон олон орны туршлага дээр тулгуурлан санхүүгийн нэгдлүүд нь эдийн засагт зерэг нөлөөтэй ч мэдээллийн ил тод байдал, зохицуулалтгүй бүрэлдэхүүн хэсэгт хяналт тавих асуудлаар эрсдэлийн цоорхой үүсэж байгааг онцолж, хяналтын уялдаа холбоо, олон улсын хамтын ажиллагааны ач холбогдлыг тэмдэглэсэн. Харин Borsuk ба Dzuryk (2016) FICOD (“Financial Conglomerates Directive”, EU Directive

2002/87/EC) удирдамжийн хэрэгжилтийг шүүмжилж, SPV (Special Purpose Vehicle) болон финтек зэрэг зохицуулалтгүй хэсгүүдийг хяналтад хамруулах, толгой компанийн хяналтыг сайжруулах, хямралын үед төвлөрсөн хариу арга хэмжээ авах тогтолцоо шаардлагатайг дурдсан. Эдгээр нийтлэг зохицуулалт, хандлага нь эрсдэлийг цогцоор үнэлэх, олон улсын мэдээллийн

солилцоог дэмжих, байгууллагын засаглал, дотоод хяналтыг сайжруулахад чиглэж байна.

Судалгааны ажлын дараагийн бүлэгт санхүүгийн нэгдэл болон түүний хяналт шалгалтын тухай, гуравдугаар бүлэгт олон улсын туршлага, Монгол Улсын өнөөгийн байдлыг тусгасан бол сүүлийн бүлэгт дүгнэлт, саналыг дэвшүүлсэн болно.

## II. САНХҮҮГИЙН НЭГДЭЛ БА ТҮҮНИЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ОЙЛГОЛТ

### 2.1. САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ

Санхүүгийн нэгдэл гэдэг нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн салбаруудыг хамарсан, нийтлэг удирдлага, эзэмшил дор үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын цогц бөгөөд санхүүгийн үйлчилгээний өргөн цар хүрээг хамарч, хөрөнгө оруулалтын олон төрлийн стратеги, үйл ажиллагааг нэгтгэдэг онцлогтой (OECD, 2021; FSB, 2022) гэж тодорхойлсон бол “Санхүүгийн нэгдэл” гэж банк, даатгал, ББСБ, хөрөнгө оруулалтын компани зэрэг санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хоёр ба түүнээс дээш байгууллага нь нэг толгой компанийн шууд болон шууд бус хяналт дор, харилцан уялдаатайгаар үйл ажиллагаа явуулж буй бүтцийг ойлгоно (Joint Forum, 2012; BCBS, 2021) гэжээ.

Дэлхийн банк (1995)-ны дурдсанаар санхүүгийн нэгдлийг үндсэн гурван төрөлд хуваасан. Үүнд:

#### 1. Bank-led conglomerates (Банк

#### давамгайлсан нэгдлүүд):

Энэ төрлийн нэгдэл нь банкны байгууллага зонхилох байр суурьтай бөгөөд бусад санхүү, даатгалын байгууллагууд нь нэмэлт болон дэмжих үйлчилгээ үзүүлдэг бүтэцтэй байдаг.


#### 2. Insurance-led conglomerates (Даатгал давамгайлсан нэгдлүүд):

Энэ бүтэц нь даатгалын байгууллага гол байр суурийг эзэлж, банкнууд болон хөрөнгө оруулалтын компаниуд нь туслах, нэмэлт үйлчилгээ үзүүлэх байдлаар оролцдог.

#### 3. Investment-led conglomerates (Хөрөнгө оруулалт давамгайлсан нэгдлүүд):

Энэ төрлийн нэгдэлд хөрөнгө оруулалтын банк эсхүл хөрөнгө удирдлагын компаниуд голлох байр суурийг эзэлдэг бөгөөд банк, даатгалын байгууллагуудыг багтаан цогц байдлаар үйл ажиллагаа явуулдаг (World Bank, 1995).

**Зураг 1.** Дэлхийн санхүүгийн зах зээл дэх санхүүгийн нэгдлийн ерөнхий бүтэц



Эх сурвалж: 2008/2025 editions of the SNA, ESA 2010

## 2.2. САНХҮҮГИЙН НЭГДЛИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

### Эрт үе (19–р зууны сүүл – 20–р зууны эхэн үе):

Санхүүгийн нэгдлийн гарал үүсэл нь 19–р зууны сүүлээс Европ, Америкийн томоохон банк, санхүүгийн байгууллагуудаас эхэлсэн байна. Энэ үед банк, даатгалын компани, хөрөнгө оруулалтын фирмүүд нь хууль эрх зүйн нарийн зохицуулалттай, харьцангуй тусдаа, бие даасан үйл ажиллагаа явуулдаг байж байгаад нэгджээ.

### Их хямрал ба зохицуулалтын үе (1930–1970–аад он):

1930–аад онд гарсан Их хямралын дараа, ялангуяа АНУ–д засгийн газраас санхүүгийн зах зээлийг хатуу зохицуулах болсон. Жишээлбэл, 1933 оны Glass–Steagall Act хуулиар банкнуудыг хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэхийг хориглож, банк, даатгал, хөрөнгө оруулалтын компаниудын хоорондын хил заагийг

тодорхой заагласан нь санхүүгийн нэгдлийн хөгжлийг хязгаарласан байна.

### Дэлхий нийтийн чөлөөлөлт, либералчлалын үе (1980–1990–ээд он):

1980–аад оноос дэлхийн санхүүгийн зах зээлд чөлөөлөлт өрнөж эхлэв. Энэ үеийн гол өөрчлөлтүүд:

- АНУ–д 1999 онд Gramm–Leach–Bliley Act батлагдан Glass–Steagall хуулийг цуцалж, банк, үнэт цаасны компани, даатгалын компаниуд хоорондоо нэгтгэх, худалдан авах боломжийг бүрдүүлсэн.
- Европын Холбоо нэгдсэн санхүүгийн зах зээлийг бий болгож, «универсал банкны» системийг дэмжиж, банк, даатгалын компаниудыг нэгтгэсэн «банк–даатгал» (bancassurance) бүтэц үүссэн.
- Энэ үед гарч ирсэн томоохон нэгдлүүд:

- Citigroup (АНУ) нь 1998 онд Citibank болон Travelers Insurance компаниуд нэгдсэнээр байгуулагдсан.
- ING Group (Нидерланд) нь 1990 онд томоохон оролцогчдын нэгдлээр байгуулагдаж, Европын банк-даатгалын том тоглогч болсон.
- Deutsche Bank (Герман) даатгал, хөрөнгө удирдлагын салбар луу хүчтэй орж, иж бүрэн санхүүгийн нэгдэл болон хөгжсөн.

### **Өргөжилтийн үе (2000–аад он):**

2000–аад оны эхээр санхүүгийн нэгдлүүд асар хурдтай өргөжин, үйл ажиллагаа нь илүү нарийн төвөгтэй болсон:

- Банк, даатгал, хөрөнгө оруулалт, үнэт цаасны үйлчилгээ нэгтгэн үзүүлдэг томоохон глобал нэгдлүүд гарч ирсэн.
- Дериватив, бүтцийн санхүүгийн (structured finance) бүтээгдэхүүнүүдийг нэгдлүүдийн дотор өргөнөөр ашигласан.
- HSBC, JPMorgan Chase, BNP Paribas, Allianz зэрэг компаниуд олон улсад өргөн хүрээгээр үйл ажиллагаагаа тэлсэн.

### **Дэлхийн санхүүгийн хямрал ба зохицуулалтын шинэчлэл (2007–2009):**

2007–2009 оны дэлхийн санхүүгийн хямрал нь томоохон санхүүгийн нэгдлүүдийн сул талыг ил болгосон. Citigroup, AIG, RBS зэрэг байгууллагуудын том хэмжээ, төвөгтэй бүтэц нь эдгээр компанийг засгийн газраас тусламж авах шаардлагыг бий болгосон.

Үүний хариуд дэлхий нийтээрээ

зохицуулалтаа чангаруулсан:

- Базель III стандарт (2009–2010): Хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварын шалгуурыг нэмэгдүүлсэн.
- АНУ-ын Dodd–Frank хууль (2010): Системийн нөлөө бүхий санхүүгийн байгууллагуудад (SIFI) нарийн хяналт тавих болсон.
- Европын Solvency II журам (2016): Даатгал давамгайлсан нэгдлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулсан.

Эдгээр зохицуулалтууд нь санхүүгийн нэгдлүүдийг илүү ил тод болгож, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, өндөр эрсдэлтэй үйл ажиллагааг хязгаарласан.

### **Хямралын дараах бүтэцлэлт ба дижитал шилжилт (2010–аас одоо хүртэл):**

Хямралын дараа санхүүгийн нэгдлүүд дахин бүтэцлэлт хийж, эрсдэл өндөртэй, үндсэн бус бизнесээ цөөлж эхэлсэн. Гэвч энэ үед дижитал санхүүгийн эрин эхэлсэн:

- Банк, финтек компани, даатгалын компани, хөрөнгө удирдлагын компаниуд хоорондоо хамтран ажиллаж эхэлсэн.
- Санхүүгийн нэгдлүүд цахим банк, төлбөр тооцоо, хөрөнгийн удирдлага, дижитал даатгал (insurtech)-ын салбарт хүчтэй орсон.

Энэ үед Хятадын Ant Group, Японы SoftBank Group зэрэг компаниуд уламжлалт санхүүгийн нэгдлүүдэд хүчтэй өрсөлдөгч болсон.

### **Одоогийн чиг хандлага, цаашдын төлөв (2020–иод оноос хойш):**

Санхүүгийн нэгдлүүд технологийн дэвшил, хууль эрх зүйн өөрчлөлт, өрсөлдөөнтэй холбоотойгоор тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байна. Үүнд:

- Дижиталчлал: Технологи, дата мэдээллийг ашиглан хэрэглэгчдэдээ нэгдсэн үйлчилгээ үзүүлэх болсон.
- Big Tech компаниудтай өрсөлдөх, тэдэнтэй хамтрах чиглэлээр илүү идэвхтэй ажиллаж байна (Google, Apple, Amazon, Facebook гэх мэт).
- Зохицуулалтын асуудлууд: Дэлхий даяар санхүүгийн тогтвортой байдал, цахим аюулгүй байдал, хэрэглэгчийг хамгаалах асуудлаар зохицуулалтаа

улам чангаруулж байна.

Санхүүгийн нэгдлүүд энгийн банкны үйлчилгээнээс эхлээд өнөөгийн олон төрлийн үйлчилгээг цогцоор үзүүлдэг олон улсын нарийн төвөгтэй байгууллага болтлоо хөгжсөн байна. Санхүүгийн нэгдлийн хөгжлийн түүх нь хууль эрх зүйн зохицуулалт, зах зээлийн өөрчлөлт, технологийн дэвшилтэй нягт уялдаатай бөгөөд эдгээр байгууллагууд нь дэлхийн санхүүгийн тогтолцооны чухал хэсэг болж, орчин үеийн шаардлагуудад дасан зохицож байна.

### 2.3. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ, ЗОРИЛГО

Санхүүгийн нэгдэл нь эдийн засгийн үр ашиг, үйл ажиллагааны өртөг бууруулах боломжийг олгодог хэдий ч эрсдэлийн төвлөрөл, ашиг сонирхлын зөрчил зэрэг олон асуудал дагуулдаг (OECD, 2021). Тиймээс санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд зохистой хяналт, шалгалт, ил тод тайлагналын шаардлага тавигддаг (FSB, 2022).

Ангил (British Overseas Territory)-ийн Санхүүгийн үйлчилгээний хорооны (FSC) журамд дурдсанаар (R.S.A. с.F28 хуулийн 61 дүгээр зүйлд үндэслэн баталсан) жижиг боловч нэлээд хөгжсөн санхүүгийн орчинд “нэгдлийн хяналт шалгалт” гэдэг ойлголтыг хэрхэн авч үзэхийг томъёолжээ.

Журамд:

- **Хост /олон улсын/ зохицуулагчийн** (host regulator) үүрэг: Гадаадын байгууллагын салбар эсхүл охин компанид (branch/subsidiary) хяналт тавих,
- **Дотоодын /үндэсний/ зохицуулагчийн** (home regulator) үүрэг: Дотоодын санхүүгийн нэгдлийг нэгдсэн байдлаар хянах хэлбэрийн зохицуулалтын талаар дурдсан.

Энэхүү журам нь санхүүгийн нэгдлийн хяналтыг нийтлэг буюу бүлгийн түвшний хандлагаар хэрэгжүүлэх зохицуулалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон баримт бичиг юм. Энэхүү хандлага нь зөвхөн нэг компанийн үйл ажиллагаанд бус, тухайн компанийн харьяалагдах бүх нэгжийн эрсдэлийг хамарсан цогц хяналт байхыг

шаарддаг. Хяналт нь тоон үзүүлэлтүүд (жишээлбэл, хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадвар) болон чанарын үнэлгээ (жишээлбэл, дотоод хяналт, засаглал, эрсдэлийн удирдлага)–д үндэслэнэ (Anguilla Financial Services Commission, n.d.).

Журамд хянан зохицуулагчийн үүргийг “хост зохицуулагч” болон “дотоодын зохицуулагч” гэсэн хоёр чиглэлээр тодорхойлжээ. Хост зохицуулагчийн хувьд гадаадын зохицуулалтын байгууллагын хяналтад байдаг компани тухайн улсад үйл ажиллагаа явуулах тохиолдолд олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын

дагуу нэгдсэн хяналтад хамрагдаж байгаа эсэхийг баталгаажуулахыг шаарддаг. Харин дотоодын зохицуулагчийн хувьд, тухайн нэгдлийн бүтэц, дотоодын болон хилийн чанад дахь охин компани, салбаруудын харилцан хамаарал зэргийг харгалзан бүлгийн түвшний эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалт явуулдаг. Мөн энэхүү баримт бичиг нь улс орнуудын зохицуулалтын байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо нь нэгдсэн хяналтын салшгүй хэсэг болохыг онцолжээ (Anguilla Financial Services Commission, n.d.).

## Зураг 2. Санхүүгийн нэгдлийн үйл ажиллагааг хянан зохицуулах арга



Эх сурвалж: OECD, 2021

Санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалт нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, нэгдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, эрсдэлд тэсвэртэй

байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн чухал үүрэгтэй. Үндэсний болон олон улсын байгууллагууд (жишээлбэл, ОУВС, Дэлхийн банк, OECD, FSB) дараах үндсэн чиглэлүүдэд анхаарч байна. Үүнд:

**Хүснэгт 1.** Санхүүгийн нэгдлийн үйл ажиллагааг хянах чиглэл

Эрсдэлийн удирдлага ба хяналт	<ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх, сайжруулах санал зөвлөмж өгөх</li> <li>• Санхүүгийн нэгдлийн хэмжээнд эрсдэлийн төвлөрөл, хөрвөх чадвар, капиталын зохистой байдалд үнэлгээ өгөхөд оршино (OECD, 2021).</li> </ul>
Санхүүгийн тогтвортой байдлыг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Тэдгээрийн дампуурлаас үүдэх гинжин үр дагавраас урьдчилан сэргийлэх</li> <li>• Тогтвортой, тасралтгүй санхүүжилтийн эх үүсвэрийг хадгалах</li> <li>• Санхүүгийн зах зээлийн итгэлийг хадгалах, дунд хугацааны эрүүл өсөлтийг дэмжихэд оршино (World Bank, 2019).</li> </ul>
Ил тод байдлын дэмжлэг	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн тайлан, удирдлагын тайлагналын чанарыг үнэлэх</li> <li>• Хяналтын явцад илэрсэн зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг бодлогын түвшинд хүргэх</li> <li>• Зах зээлийн оролцогчдод шаардлагатай мэдээллийг нээлттэй, цаг хугацаанд нь хүргэхийг зорьдог (IMF, 2021).</li> </ul>
Зах зээлийн сахилга бат ба хариуцлага	<ul style="list-style-type: none"> <li>• Удирдлагын хариуцлагыг тодорхой болгох</li> <li>• Эрсдэл үүсгэгч үйлдэл, шийдвэрт зохих хариуцлага тооцох үндэслэл бүрдүүлэх</li> <li>• Санхүүгийн сахилга бат, ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байхад чиглэнэ (FSB, 2022).</li> </ul>

*Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт*

Эдгээр чиг үүрэг, зорилтууд нь зөвхөн тухайн санхүүгийн нэгдлийн дотоод үйл ажиллагааг төдийгүй, өргөн хүрээтэйгээр санхүүгийн

системийн тогтвортой байдал, сайн засаглал, итгэлцлийг дэмжих болон эрсдэлийг бууруулах зохицуулалт бий болгох үндэс суурь болдог.

## III. ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

### 3.1. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАРЧИМ, ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн салбарын тогтвортой байдал, аюулгүй байдлыг хангах зорилгоор олон улсын байгууллагууд төрөл бүрийн стандарт, зөвлөмжийг боловсруулж, улс орнуудад хэрэгжүүлэхийг зөвлөдөг. Эдгээрээс Joint forum, Европын холбоо зэрэг байгууллагуудын гаргасан гол стандарт, зөвлөмжүүдийг авч үзсэн.

#### **Joint forum:**

**Joint forum** нь Банкны хяналтын хороо (Basel Committee), Үнэт цаасны хяналтын олон улсын хороо (IOSCO), Даатгалын хяналтын олон улсын хороо (IAIS)-ийн хамтран үүсгэсэн байгууллага. Санхүүгийн нэгдлүүдийн холбоо хамаарлын түвшин нэмэгдэж, салбаруудын уялдаа гүнзгийрч байгаатай уялдуулан эдгээр нэгдлийг

хэрхэн салбар хооронд зохицуулалттайгаар хянах, системийн эрсдэлийг бууруулах, хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог сайжруулах асуудлыг шийдвэрлэх нь зохицуулалтын гол зорилт болж байна. Иймд Joint forum нь Санхүүгийн нэгдлүүдийн капиталын нэгдсэн

шаардлага, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, бүлгийн түвшний зохицуулалт зэрэгт чиглэсэн бодлогын удирдамж, “Core Principles”-ийг уялдуулах гарын авлага, судалгааны тайлан боловсруулж, үндэсний зохицуулагч байгууллагуудад сайн дурын хэрэгжүүлэлтийн хэлбэрээр танилцуулдаг.

## Хүснэгт 2. Joint forum-аас гаргасан зарчим

№	Зарчмын агуулга	Тайлбар
I	Supervisory Powers and Authority (Хянан шалгагчийн эрх мэдэл, бүрэн эрх) /1–4–р зарчим/	Санхүүгийн нэгдэлд хяналт тавих эрх зүйн үндэс, зохицуулагч байгууллагын хараат бус байдал, үйл ажиллагааны нөөц бололцоо, мэдээлэл солилцооны эрх зүйн зохицуулалт зэргийг хамаарна. <ul style="list-style-type: none"> <li>- Эрх зүйн тогтолцоо: Нэгдэлд хүрч үйлчлэхүйц тодорхой эрх олгогдсон байх ёстой.</li> <li>- Хараат бус байдал: Хяналтын байгууллага шийдвэр гаргахдаа улс төрийн болон бизнесийн дарамтаас ангид байх ёстой.</li> <li>- Нөөцийн хүрэлцээ: Шаардлагатай хүний нөөц, төсөв, техник хэрэгслээр хангагдсан байх шаардлагатай.</li> </ul>
II	Supervisory Responsibility (Хянан шалгагчийн хариуцлага) /5–9–р зарчим/	Нэгдлийн зохицуулалтыг хариуцагч нэг гол байгууллага тодорхой байх ба бусад зохицуулагчтайгаа уялдаа холбоотой ажиллах шаардлагатай. <ul style="list-style-type: none"> <li>- Зохицуулагчдын хамтын ажиллагаа: Салбар хоорондын мэдээлэл солилцоо, хамтарсан хяналт.</li> <li>- Нэгдлийн хяналтын хүрээ: Бүх охин компаниуд, хамаарал бүхий этгээдүүдийг хамарсан нэгтгэсэн хяналт тавих.</li> </ul>
III	Corporate Governance (Корпорацын засаглал) /10–14–р зарчим/	Санхүүгийн нэгдлийн засаглалын тогтолцоо ил тод, хариуцлагатай, үр ашигтай байх шаардлагатай. <ul style="list-style-type: none"> <li>- Группийн бүтцийн ил тод байдал: Охин компаниудын өмчлөлийн бүтэц тодорхой байх.</li> <li>- ТУЗ-ийн үүрэг: Стратеги төлөвлөлт, эрсдэлийн удирдлагад ТУЗ бодит оролцоотой байх.</li> <li>- Удирдлагын зохистой бүтэц: Группийг бүхэлд нь удирдах тодорхой бүтэцтэй байх.</li> </ul>
IV	Capital Adequacy and Liquidity (Хөрөнгийн хүрэлцээ ба хөрвөх чадвар) /15–20–р зарчим/	Санхүүгийн нэгдлийн санхүүгийн эрүүл байдлыг хангах үүднээс хөрөнгийн болон хөрвөх чадварын удирдлагыг нэгдсэн байдлаар хянана. <ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгийн зохистой байдлын төлөвлөлт: Нэгдлийн капиталын стратеги төлөвлөгөөтэй байх.</li> <li>- Капиталын дотоод шилжилтийг хязгаарлах: Толгой компани, охин компани хоорондын санхүүгийн нөөцийн зохисгүй шилжилтийг хянах.</li> <li>- Хөрвөх чадварын удирдлага: Бүх охин компаниудын төлбөрийн чадварыг нэгдсэн байдлаар удирдах.</li> </ul>

V	Risk Management (Эрсдэлийн удирдлага)– /21–29–р зарчим/	<p>Санхүүгийн нэгдэлд нэгдсэн эрсдэлийн соёл төлөвшүүлэх, гол эрсдэлийн төрлүүдийг удирдах бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрсдэлийн соёл: ТУЗ, удирдлагын түвшинд эрсдэлийг мэддэг, хүлээн зөвшөөрдөг байх.</li> <li>- Стресс тест хийх: Янз бүрийн таамаглал дээр үндэслэн нэгдлийн тэсвэртэй байдлыг шинжлэх.</li> <li>- SPE (Single Point of Entry) бодлого: Санхүүгийн нэгдлийг бүтцийн хувьд нэг сувгаар дамжуулан шийдвэрлэх боломжтой байлгах.</li> <li>- Аутсорсингийн хяналт: Бусдад эрх олгосон үйлчилгээний эрсдэлийг хянах.</li> </ul>
---	---	---

*Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт*

Эдгээр зарчмууд нь олон улсын хэмжээнд санхүүгийн нэгдлүүдийг хянах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад зориулсан стандартчилсан аргачлал юм. Монголд одоогоор ийм түвшний нэгдсэн зохицуулалтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байгаа бөгөөд цаашид эдгээр зарчмуудыг нутагшуулах нь зүйтэй гэж үздэг байна.

### **Европын Холбоо – Solvency II зохицуулалтын систем**

Solvency II бол Европын Холбооны (ЕХ) даатгал, давхар даатгалын компаниудад зориулсан эрсдэлд суурилсан зохицуулалтын хүрээ юм. Энэ нь даатгуулагчдыг илүү сайн хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, даатгалын зах зээлийн нэгдмэл байдлыг дэмжих зорилготойгоор 2016 онд хэрэгжиж эхэлсэн.

### **Хүснэгт 3. Үндсэн бүтэц (3 тулгуур багана)**

Pillar I: Хөрөнгийн үнэлгээ ба капиталын шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Даатгалын компанийн актив болон пассивыг зах зээлийн үнэлгээгээр тодорхойлно.</li> <li>- Компаниуд эрсдэлийн түвшиндээ тохирсон минимум капиталын шаардлага (Minimum Capital Requirement– MCR) болон шийдвэрлэх капиталын шаардлага (Solvency Capital Requirement– SCR) хангах ёстой.</li> <li>- SCR нь бизнесийн бүх гол эрсдэл (даатгал, хөрөнгө оруулалт, зах зээл, үйл ажиллагааны эрсдэл)–ийг багтаан тооцдог.</li> </ul>
Pillar II: Засаглал ба эрсдэлийн удирдлага	<ul style="list-style-type: none"> <li>- Даатгалын компаниуд сайн засаглалын шаардлагуудыг хангасан байх ёстой.</li> <li>- Өөрийн эрсдэл ба төлбөрийн чадварын үнэлгээ (ORSA) хийх шаардлагатай: компани өөрийн онцлогт тохирсон эрсдэлийн профайл, капиталын шаардлагыг дотооддоо тогтоож, байнга хянаж үнэлдэг байх ёстой.</li> <li>- Удирдлагын баг, ТУЗ нь эрсдэлийг хянахад шууд оролцоотой байх шаардлага тавигддаг.</li> </ul>

<p>Pillar III: Ил тод байдал ба тайлагнал</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хяналтын байгууллага (санхүүгийн зохицуулагч) болон олон нийтэд өгөх мэдээллийн чанар, тодорхой байдлыг нэмэгдүүлэх.</li> <li>- Компаниуд зохицуулагчид зориулсан нарийвчилсан тайлан (Regular Supervisory Report – RSR) болон олон нийтэд зориулсан санхүүгийн тайлан (Solvency and Financial Condition Report– SFCR) гаргах шаардлагатай.</li> <li>- Энэ тайлагнал нь компанийн санхүүгийн эрүүл байдлыг, эрсдэлийн түвшинтэй хамт ил тод мэдээлдэг.</li> </ul>
---	--

*Эх сурвалж: Solvency II Single Rulebook*

### 3.2. ИХ БРИТАНИ УЛСЫН ТУРШЛАГА

Их Британи Улс нь 2013 онд санхүүгийн салбартаа “Twin Peaks” зохицуулалтын шинэ тогтолцоог нэвтрүүлсэн. 2001 оноос 2013 он хүртэл Санхүүгийн үйлчилгээний захиргаа Financial Services Authority (FSA) нь санхүүгийн салбарыг хянаж зохицуулж байсан бөгөөд 2008 оны санхүүгийн

хямралын үед Английн томоохон банкнуудыг дампуурлаас урьдчилсан сэргийлж чадаагүй гэсэн шалтгаанаар татан буугдсан. Тус Улс нь 2012 онд Санхүүгийн үйлчилгээний тухай хуулийг баталснаар санхүүгийн салбарыг хянаж зохицуулах үүргийг 2 байгууллагад хуваарилсан.

#### Хүснэгт 4. Их британи Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг

№	Зохицуулагч байгууллага	Чиг үүрэг
1	Санхүүгийн зохицуулах газар (FCA):	FCA нь санхүүгийн зах зээлийн шударга байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр ажилладаг. Тус байгууллага нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зах зээлийн шударга байдлыг хангах үүрэгтэй.
2	Зохистой байдлын зохицуулалтын газар (PRA):	PRA нь Английн Банкны (Bank of England) харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд банк, даатгал, хөрөнгө оруулалтын компаниудын санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадварыг хангах үүрэгтэй. Тус байгууллага нь системийн ач холбогдолтой санхүүгийн нэгдлүүдэд өндөр шалгуур тавьж, тэдгээрийн эрсдэлийг хянахад анхаардаг.

#### Санхүүгийн салбарын гол хуулиуд

- Хэрэглэгчийн зээлийн тухай хууль /Consumer Credit Act 1974/– Хэрэглэгчийн зээл олгох үйл ажиллагааг зохицуулсан гол хууль бөгөөд зээлдэгчид, хэрэглэгчдийн эрх, үүргийг тогтоосон.
- Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хууль /Financial Services and Markets Act 2000/– Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг

бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох, хянах үндсэн зохицуулалтыг тусгасан ерөнхий хууль бөгөөд FCA болон PRA эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан.

- Банкны тухай хууль /Banking Act 2009/-Банкны тухай хууль нь Английн банкны системийн тогтвортой байдлыг хангах, банкнуудын дампууралд орох эрсдэлийг бууруулах зорилготойгоор батлагдсан хууль.
- Төлбөрийн үйлчилгээний журам /Payment Services Regulations 2017/-Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалт, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, өрсөлдөөнийг дэмжих зэрэг олон чухал зохицуулалтыг агуулдаг.

Их Британи Улс нь санхүүгийн нэгдлийн тухай бие даасан хуульгүй бөгөөд дээрх хуулиуд, 2004 онд баталсан “Санхүүгийн нэгдэл ба бусад санхүүгийн бүлгийн зохицуулалтын журам”-аар зохицуулдаг. Энэхүү журам нь банк, даатгал, хөрөнгө оруулалтын салбарт зэрэг үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн нэгдлүүдийг нэгжийн түвшинд биш бүлгийн түвшинд хянах, зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлсэн журам юм. Тус журмын зорилго нь санхүүгийн нэгдлүүдийг бүлгийн түвшинд үр дүнтэй хянах, зохицуулах, салбар хоорондын эрсдэлийн тархалтаас урьдчилсан сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хяналтын давхардал болон цоорхойг арилгах зорилготой.

**Хүснэгт 5.** Их Британи Улсын санхүүгийн нэгдэл ба бусад санхүүгийн бүлгийн зохицуулалтын журам

№	Бүлгийн нэр	Тайлбар
1	Тогтоолын нэр, хүчин төгөлдөр болох хугацаа, үндсэн нэр томъёо	“Санхүүгийн нэгдэл” гэдэг нь банк, хөрөнгө оруулалт, даатгалын үйл ажиллагаа явуулдаг ААН-г нэгтгэсэн, санхүүгийн салбарын олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг группийг хэлнэ. Групп гэдэгт толгой компани, түүний охин болон хамаарал бүхий компаниудыг хамаарна.
2	Санхүүгийн нэгдэл дэх хяналтын үйл ажиллагааны зохицуулагчийн үүрэг	Зохицуулагчийг сонгох шалгуур, санхүүгийн нэгдэл мэдэгдэх мөн санхүүгийн нэгдэл шалгуурыг биелүүлэхээс татгалзах нөхцөлийг заасан.
3	Нэмэлт хяналт тавих зорилгоор хуулийн IV хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	Санхүүгийн нэгдлийн хяналтын хүрээнд эрх бүхий байгууллагуудын үүрэг
4	Санхүүгийн Үйлчилгээний тухай хуулийн 138А зүйлийн дагуух нэмэлт хяналт	Зах зээлийн дүрэм, шаардлага тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх тухай.

5	Томоохон хориг болон онцгой арга хэмжээний талаар зөвлөлдөх	Хяналтын байгууллагууд хоорондын мэдээлэл солилцож, харилцан уялдаатай хяналт хэрэгжүүлэх тухай.
6	Хяналтын байгууллагын үүрэг ба мэдэгдэл хүргүүлэх журам	Зохицуулагчийн үүрэг, мэдэгдлийг хүргүүлэх үйл явцын тухай.
7	Гадаад улсын санхүүгийн нэгдлийг хянах, зохицуулах	Гадаад улсын эрх бүхий байгууллага гэдэг нь Нэгдсэн Вант Улс (НВУ)-ын гадна оршиж, хуулиар хянах эрхтэй байгууллагыг хэлнэ. Гадаад улсын санхүүгийн нэгдэл гэдэг нь НВУ-ын гадна байрлах эцсийн хөрөнгө оруулагчтай группийг хэлнэ.
8	Гадаад улсын санхүүгийн нэгдлийг хянах	Гадаад улсын санхүүгийн нэгдэл дэх зохицуулалттай этгээдийг хянахдаа зохицуулагч нь бусад холбогдох байгууллагатай зөвшилцөж, тодорхой арга хэмжээ авахын өмнө зөвшөөрөл авах шаардлагатай.
9	Гадаад улсын банкны группийг хянан зохицуулах	Гадаад улсын банкны группийг хянахдаа зохицуулагч нь бусад холбогдох байгууллагатай зөвшилцөж, тодорхой арга хэмжээ авахын өмнө зөвшилцөх шаардлагатай.
10	Гадаад улсын группийг CRD, CRR дагуу хянах	Гадаад улсын группийг капитал шаардлагын журам (CRR) болон капитал шаардлагын удирдамж (CRD)-ийн дагуу хянах.
11	Нууц мэдээллийг задруулахгүй байх	Санхүүгийн нэгдэлтэй холбоотой нууц мэдээллийн зохицуулалт
12	Мэдээлэл цуглуулахдаа давхар тайлагналаас зайлсхийх	Мэдээлэл цуглуулахдаа зохицуулагч байгууллагууд мэдээллийг дахин шаардахгүй байх, тайлагналын давхардлыг үүсгэхгүй байх зарчмыг баримтлах ёстой.
13	Хөрөнгийн хүрэлцээ	Бүх компаниудын нийлсэн хөрөнгө дээр үндэслэн хөрөнгийн зохистой байдлын шаардлагыг тавьдаг.

Санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын аргачлал:

- Хөрөнгийн шаардлагын удирдамж / Capital Requirements Directive/

CRR Европын холбооны банкнууд, зээлийн байгууллага, хөрөнгө оруулалтын компаниуд нийтлэг мөрдөн ажилладаг бөгөөд зээлийн байгууллага болон хөрөнгө оруулалтын компанийн үйл ажиллагааг зохицуулдаг гол баримт бичиг юм.

CRR Базелын стандартад үндэслэсэн бөгөөд дэлхийн санхүүгийн хямралын дараа Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос санхүүгийн зах зээлийн хэрэгслүүд, бусад эрсдэлийг тооцох аргачлал нь бодит алдагдлыг илэрхийлж чадахгүй ба бусад санхүүгийн хяналт шалгалт дутагдалтай байсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Базел III стандартыг боловсруулсан. Энэхүү шинэчилсэн удирдамжид “зах

зээлийн эрсдэл”, “зээлийн эрсдэл”, “үйл ажиллагааны эрсдэл” гэх мэт олон асуудлыг хамарсан зохицуулалтыг нэмж тусгасан байна.

- Хөрөнгийн шаардлагын удирдамж /CRD/ Хөрөнгийн шаардлагын удирдамжийг зээлийн байгууллага, хөрөнгө оруулалтын компанийн үйл ажиллагааг хянах, Европын холбооны санхүүгийн зуучлагчдад зохистой хяналтыг хэрэгжүүлэхэд ашигладаг байна.

Банкны хувьд Их Британийн «Хөрөнгийн шаардлагын журам /CRR/» болон «Хөрөнгийн шаардлагын удирдамж /CRD/ IV»-ийн дагуу зохицуулна. Даатгалын байгууллагуудын хувьд Европын холбооны Solvency II журам-ын дагуу зохицуулна. Нэгдлийн түвшинд групп компани нь хамгийн өндөр зохицуулалтын шаардлагатай салбар (ихэвчлэн банкны салбар)-ын дагуу хөрөнгийн хүрэлцээг хангах ёстой.

### 3.3. АВСТРАЛИ УЛСЫН ТУРШЛАГА

Австралийн санхүүгийн хяналт шалгалтын тогтолцоо нь 1998 онд «Wallis Inquiry»-ийн дүгнэлтэд үндэслэгдэн шинэчлэгдэж, санхүүгийн зохистой хяналтын байгууллага болох APRA байгуулагдсан. Өмнө нь салбар тус бүрд хяналт тавьдаг байсан бол 1998

оноос хойш банк, даатгал, тэтгэврийн салбарт нэгдсэн зохистой хяналтын тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. 2017 оны шинэчлэлээр эрсдэлийн удирдлага, байгууллагын засаглал, ил тод байдал зэрэгт илүү нарийвчилсан стандартууд тогтоосон.

#### Хүснэгт 6. Австрали Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг

№	Зохицуулагч байгууллага	Чиг үүрэг
1	<b>APRA</b> – Австралийн зохистой зохицуулалтын газар	банк, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, тэтгэврийн сангийн зохистой хяналтыг хэрэгжүүлдэг, төв банкнаас тусдаа бие даасан байгууллага;
2	<b>ASIC</b> – Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо	үнэт цаас, хөрөнгө оруулалт, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн ёс зүйг хариуцдаг;
3	<b>Австралийн төв банк</b>	санхүүгийн тогтвортой байдал, бодлогын хүү, төлбөрийн системийн хяналтыг хариуцна

#### Санхүүгийн салбарын гол хуулиуд

- Banking Act 1959 – банкны үйл ажиллагаанд тавигдах зохистой шаардлагыг тодорхойлж, банкны системийн тогтвортой байдлыг хамгаалдаг;
- Insurance Act 1973 – ердийн даатгалын

компаниудад тавигдах санхүүгийн болон удирдлагын шаардлагыг зохицуулдаг;

- Life Insurance Act 1995 – амьдралын даатгалын компаниудын хариуцлага болон хөрөнгийн удирдлагын зохицуулалтыг агуулдаг;

- Superannuation Industry (Supervision) Act 1993 (SIS Act) – тэтгэврийн сангуудын зохистой үйл ажиллагаа, хөрөнгийн хамгаалалтад чиглэсэн;
- Australian Prudential Regulation Authority Act 1998 – Австралийн пруденшл зохицуулагч байгууллага болох APRA-гийн бүтэц, чиг үүргийг тогтоодог үндсэн хууль юм.

үйл ажиллагааны цар хүрээ болон хяналтын шаардлагаас нь хамааран Level 1, Level 2, Level 3 гэсэн гурван түвшинд ангилан зохицуулдаг.

Үүнээс Level 3 ангилалд нь **конгломерат групп** хамаарагдах ба группийн толгой компани нь банк, ердийн даатгалын компани, эсхүл амьдралын даатгалын компани байна. Тус ангилалд APRA-с зохицуулалттай болон зохицуулалтгүй салбарууд орно.<sup>5</sup>

APRA нь санхүүгийн байгууллагуудыг бүтэц,

### Хүснэгт 7. Австрали Улсын санхүүгийн нэгдлийн /Level-3/ хяналт шалгалтын стандарт, зөвлөмж

Стандартын код	Стандартын нэр	Хамрах агуулга
3PS001	Нэр томъёоны тодорхойлолт	(APRA)-аас гаргасан зохицуулалтын стандартуудын хүрээнд хэрэглэгдэх гол нэр томъёонуудыг тодорхойлсон баримт бичиг юм. Энэхүү стандарт нь Level 3 толгой байгууллагуудад хамаарах бусад зохицуулалтын стандартуудыг зөв ойлгож хэрэглэхэд шаардлагатай нэр томъёоны тодорхойлолтыг агуулдаг.
3PS110	Хөрөнгийн зохистой байдал	Хөрөнгийн зохистой байдлыг хангах үүргийг тодорхойлдог. Хөрөнгийн удирдлагын бодлого, ICAAP, салбар тус бүрийн эрсдэлд нийцүүлэн нийт капиталын шаардлагыг тооцох, дотоод гүйлгээ болон тайлагналын ил тод байдал зэргийг тусгасан.
3PS221	Aggregate Risk Exposures Эрсдэлийн хяналтын практик зөвлөмжүүд	Эрсдэлийг тодорхойлж, хэмжих, хянах, тайлагнах, хязгаарлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, Зах зээлийн нөхцөл байдал, гол эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлтүүдийн нөлөөг урьдчилан таамаглах зорилгоор ирээдүйг харсан шинжилгээ, стресс тест хийх зэргийг тусгасан.
3PS222	Intra-group Transactions and Exposures Дотоод гүйлгээний практик зөвлөмжүүд	Санхүүгийн групп доторх байгууллагуудын хоорондын гүйлгээ, хамаарлаас үүдэлтэй эрсдэлийг хэрхэн тодорхойлох, үнэлэх, хянах зэрэгт өгсөн зөвлөмж Зарим төрлийн дотоод гүйлгээнд эрсдэлийн хязгаар (exposure limits) тогтоож, группийн санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлнэ.

<sup>5</sup> [https://www.apra.gov.au/sites/default/files/Prudential-Standard-3PS-001-Definitions-%28July-2017%29\\_0.pdf](https://www.apra.gov.au/sites/default/files/Prudential-Standard-3PS-001-Definitions-%28July-2017%29_0.pdf)

<b>3PS310</b>	Audit and Related Matters Аудит	Аудитын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулж, аудитын үр дүнг APRA–д шууд хүргүүлэх, дотоод хяналтыг сайжруулах, санхүүгийн мэдээллийн найдвартай байдлыг хангах зорилготой.
---------------	------------------------------------	---

Санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын аргачлал:

### **SRI загвар**

APRA нь хяналт шалгалтын эрчим, эрсдэлийг үнэлэх шинэ загвар болох Supervision Risk and Intensity (SRI) загварыг нэвтрүүлсэн. Энэ SRI загвар нь өмнө ашиглагдаж байсан Probability and Impact Rating System (PAIRS) болон Supervisory Oversight and Response System (SOARS)–ийг орлох бөгөөд эдгээр нь 2002 оноос хойш хэрэгжиж ирсэн болно.

### **Risk-based Supervision**

APRA голчлон “эрсдэлийн үнэлгээ ба хариу арга хэмжээний систем” (PAIRS–SOARS) аргыг ашиглан, байгууллагын эрсдэлийн магадлал ба нөлөөллийг үнэлж, түүнд тохирсон хяналт шалгалт хийдэг.

### **Prudential review**

“Prudential review” буюу бодлогын шалгалт нь тухайн байгууллагын гол эрсдэлүүд болон тэдгээрийг удирдах хяналт, системүүд хэр үр дүнтэй ажиллаж байгааг нарийвчлан дүгнэдэг чухал үйл ажиллагаа юм.

Шалгалтын давтамж, цар хүрээ нь эрсдэлийн үнэлгээний дүнгээс шалтгаалж өөрчлөгдөнө.

### **Стресс тест**

CPS220 заалт: Бүх APRA–гаас зохицуулагддаг байгууллага, Level 2/3 групп нь ирээдүйг харсан нөхцөл байдлын шинжилгээ (forward-looking scenario analysis) болон стресс–тест хөтөлбөртэй байх ёстой. Эдгээр нь байгууллагын хэмжээнээс, бизнесийн төрөл, нарийн төвөгтэй байдлаас хамаарч, “хүчтэй боловч бодитой” нөхцөлүүдэд хэрхэн тэсвэрлэхийг үнэлнэ.<sup>6</sup>

Хөрөнгийн стандартууд нь зохицуулалттай байгууллага ICAAP (Дотоод Капиталын Зохистой Байдлын Үнэлгээний Процесс)–даа стресс тест ба нөхцөл байдлын шинжилгээг тусгахыг шаарддаг. Эдгээр стресс тест, нөхцөл байдлын шинжилгээ нь тухайн байгууллагын онцлог болон түүнд тулгарч буй эрсдэлийн өртөлтөд тохируулан хийгдэнэ. Нөхцөл байдлууд нь байгууллагын хүлээн авч болзошгүй бүх чухал эрсдэлийг хамрах чиглэлтэй байдаг.<sup>7</sup>

<sup>6</sup> <https://www.apra.gov.au/sites/default/files/Prudential-Standard-CPS-220-Risk-Management-%28July-2017%29.pdf?utm>

<sup>7</sup> <https://www.apra.gov.au/sites/default/files/2023-12/Prudential%20Practice%20Guide%20CPG%20110%20Internal%20Capital%20Adequacy%20Assessment%20Process%20and%20Supervisory%20Review.pdf>

## 3.4 АЗИЙН ОРНУУДЫН ТУРШЛАГА (СИНГАПУР УЛС, ЯПОН УЛС, ӨМНӨД СОЛОНГОС УЛС)

### 3.4.1 Сингапур Улс

Сингапурын Төв банк (Monetary Authority of Singapore, MAS) нь тус улсын Төв банк болон санхүүгийн зохицуулагчийн үүргийг хослуулан гүйцэтгэдэг байгууллага юм. MAS нь санхүүгийн бүх салбарыг хянах бүрэн эрхтэй бөгөөд санхүүгийн үйлчилгээний тухай хууль, зохицуулалт, удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь нэгдлийн түвшний эрсдэлийн үнэлгээ, стресс тест, мэдээлэл задлан шинжлэх аргачлалыг ашиглан санхүүгийн байгууллагуудын тогтвортой байдлыг хангах чиглэлээр ажилладаг.

#### Санхүүгийн салбарын гол хуулиуд

- Monetary Authority of Singapore Act (MAS Act): Сингапурын Мөнгөний зохицуулалтын газрын тухай хууль нь MAS-д санхүүгийн байгууллагуудыг зохицуулах, хянах өргөн эрх мэдлийг олгодог.
- Banking Act: Банкны үйл ажиллагааг зохицуулдаг.
- Securities and Futures Act (SFA): Үнэт цаас, фьючерсийн зах зээлийг зохицуулдаг.
- Insurance Act: Даатгалын салбарыг зохицуулдаг.
- Financial Advisers Act (FAA): Санхүүгийн зөвлөх үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулдаг.
- Payment Services Act (PSA): Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулдаг.

- Financial Services and Markets Act (FSMA, 2022): Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн салбаруудыг нэгтгэн зохицуулах зорилгоор батлагдсан хууль.

Сингапур Улс нь 2013 онд “Санхүүгийн холдинг компанийн тухай хууль”-ийг баталснаар санхүүгийн нэгдлийг хянах, зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Тус хуульд:

“Financial holding company” (санхүүгийн холдинг компани): “Санхүүгийн холдинг компани” гэж дараах шаардлагыг хангасан холдинг компанийг хэлнэ:

- а) Сингапурт үүсгэн байгуулагдсан банк эсхүл Сингапурт байгуулагдсан, бүртгэгдсэн, үүсгэн байгуулагдсан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь дор хаяж нэг охин компани эзэмшдэг байх;
- б) Тус охин компани (эсхүл санхүүгийн байгууллагын статустай охин компаниуд нийлсэн байдлаар) нь уг холдинг компанийн нийт хөрөнгө, капитал, өр төлбөр эсхүл орлогын 50 буюу түүнээс дээш хувийг бүрдүүлдэг байх.” гэж тусгасан.

**Хүснэгт 8.** Сингапур Улсын Санхүүгийн холдингийн тухай хууль, 2013

№	Бүлгийн нэр	Тайлбар
1	Удиртгал	Хуулийн нэр, хэрэгжиж эхлэх хугацаа, нэр томьёо болон үндсэн ойлголтыг тодорхойлсон хэсэг.
2	Мэдээлэл авах эрх	Санхүүгийн зохицуулагч байгууллага нь санхүүгийн холдинг компаниудаас шаардлагатай мэдээллийг авч, хяналт тавих эрхтэй байгааг заасан.
3	Санхүүгийн холдинг компанийг томилох	Зохицуулагч байгууллага (MAS) тодорхой нөхцөлд компанийг “санхүүгийн холдинг компани” гэж нэрлэх, бүртгэх, холдинг байх нэршлийг хүчингүй болгох, нэр ашиглахыг хориглох, үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлох харилцааг зохицуулна.
4	Хувьцаа болон хяналтын багцын өөрчлөлт	Банкны охин компани эсэхээс хамааран томоохон хувьцаа эзэмшил, саналын эрх, хяналтын багц шилжүүлэх, урьдчилсан зөвшөөрөл авах, давж заалдах эрх зэрэг хувьцааны харилцааг зохицуулна.
5	Эрсдэл ба хөрөнгө оруулалтын хязгаар	Хэт их эрсдэлээс сэргийлэх, удирдлагын ашиг сонирхлын мэдүүлэг, хувьцаа болон үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын дээд хязгаарыг тогтооно.
6	Өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангах шаардлага	Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, капиталын доод хэмжээ, капиталын хүрэлцээ, хөшүүрэг, тэдгээрийн хэрэгжилтийг хянах эрхийг зохицуулна.
7	Аудит, хяналт шалгалт ба мөрдөн шалгалт	Жилийн аудит, группийн оролцогч компаниудад шалгалт хийх, тусгай мөрдөн шалгалт явуулах, гадаад хяналтын байгууллагатай хамтран ажиллах, шалгалтын нууцлалыг хамгаалах заалтууд орно.
8	Холдинг компанид хяналт тогтоох эрх	Дампуурах нөхцөл үүссэн үед зохицуулагч байгууллага хяналт тогтоох, үр дагавар, хугацаа, албан тушаалтны хариуцлага, татан буулгах журмыг тодорхойлно.
9	Гадаад зохицуулагч байгууллагад туслалцаа үзүүлэх	Гадаад зохицуулагч байгууллагуудад мэдээлэл өгөх, хамтран ажиллах нөхцөл, эрх зүйн хамгаалалт, хариуцлага, зөрчлийн заалтуудыг зохицуулна.
10	Бусад зохицуулалт	Журам батлах, мэдэгдэл хүргэх, гүйцэтгэх захирал томилох/чөлөөлөх, албан тушаалтанд хариуцлага тооцох, шүүхийн харьяалал, прокурорын зөвшөөрөл, бусад холбогдох зохицуулалтуудыг багтаана.

**Санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын аргачлал:****CRAFT: MAS-ийн боловсруулсан эрсдэлийн үнэлгээний аргачлал.**

Сингапур Улсын санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтад CRAFT аргачлал ашиглагддаг бөгөөд MAS-ийн албан ёсны

зохицуулалтын хүрээнд хэрэгждэг. Энэхүү аргачлал нь санхүүгийн нэгдлийн бүтцийн төвөгтэй байдал, дамжих эрсдэл, санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд чиглэгдсэн.

**ICAAP: Хөрөнгийн хүрэлцээтэй байдлын үнэлгээ**

ICAAP (Internal Capital Adequacy Assessment Process) буюу “Хөрөнгийн хүрэлцээтэй байдлын үнэлгээний аргачлал”-ыг санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг үнэлэх, удирдах зорилгоор ашигладаг. ICAAP-ийг ашиглахдаа MAS-ийн гаргасан удирдамж, журам, зааварчилгааг дагаж мөрддөг. Эдгээр удирдамж нь санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн хүрэлцээтэй байдлыг үнэлэх, эрсдэлийг удирдах, зохистой хөрөнгийн хэмжээ тогтоох зэргийг хамардаг.

**ORSA: Даатгалын салбарт ашиглагддаг дотоод эрсдэлийн болон хөрөнгийн үнэлгээ**

Сингапур Улсын даатгалын компаниуд нь ORSA ашиглан эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээг хийдэг бөгөөд жил бүр эрсдэлийн нөхцөл байдал болон хөрөнгийн урьдчилсан үнэлгээг хийдэг. Даатгалын групп, конгломератуудад (даатгалын

бүлгүүд) хамаарна.

**3.4.2 Япон Улс**

Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA) нь Японы санхүүгийн зах зээлийг хянадаг гол зохицуулалтын байгууллага юм. Үндсэн чиг үүрэг нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах үүрэгтэй бөгөөд санхүүгийн хэрэгсэл, тэр дундаа мөнгөний зах зээлтэй холбоотой дүрэм журам, удирдамж гаргаж санхүүгийн байгууллагад хяналт тавихаас гадна санхүүгийн бүлэг буюу конгломерат түвшинд хяналт шалгалт хийх зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Харин Японы Төв банк (BOJ) нь мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас гаргаж, мөнгөний зах зээлд нөлөөлөх нээлттэй зах зээлийн үйл ажиллагаа явуулдаг.

**Хүснэгт 9. Япон Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг**

№	Зохицуулагч байгууллага	Чиг үүрэг
1	FSA Financial Services Agency	Санхүүгийн системтэй холбоотой бодлого боловсруулах, төлөвлөх, хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагуудыг шалгах, хянах, үнэт цаасны арилжаанд хяналт тавих үүрэгтэй. <sup>8</sup>
2	BOJ Bank of Japan	Японы Төв банк, Мөнгөний бодлого хэрэгжүүлдэг, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлдэг.
3	MOF Ministry of Finance	Сангийн яам, Бодлогын түвшинд оролцдог, FSA-г хянан удирддаг.

<sup>8</sup> [https://www.fsa.go.jp/en/about/pamphlet\\_e.pdf](https://www.fsa.go.jp/en/about/pamphlet_e.pdf)

**Санхүүгийн салбарын гол хуулиуд:**

- Банкны салбар – 1981 оны Банкны тухай хууль (Banking Act) болон FSA-ийн “Comprehensive Guidelines for Supervision of Major Banks, etc.” – ээр хянадаг.
- Үнэт цаас, хөрөнгө оруулалтын салбар – 2006 оны Financial Instruments and Exchange Act (FIEA) нь брокер дилер, хөрөнгө оруулалтын сан, нээлттэй компанийн ил тод тайлагнал, дотоод хяналтын стандартыг тогтоодог.
- Даатгалын салбар – 1996 оны Insurance Business Act болон дагалдах FSA-ийн “Comprehensive Guidelines for the Supervision of Insurers” нь даатгалын компаниудын үйл ажиллагааны зөвшөөрөл, бизнесийн сайжруулалтын зөвлөмж, лиценз хүчингүй болгох хүртэлх арга хэмжээг тусгасан.

Японы “Санхүүгийн нэгдлүүдийн хяналтын зөвлөмж болох (Guideline for Supervision of Financial Conglomerates) 2019 оны 12 дугаар

**3.4.3 Өмнөд Солонгос Улс**

Солонгос Улсад 2000 оны эхэнд санхүүгийн нэгдэлд харьяалагддаг компаниуд хамтран дампуурсан хэргүүдээс болж санхүүгийн нэгдлүүдийн талаар 2006 оноос судалж эхэлсэн байна<sup>10</sup>. Олон улсын валютын сан (IMF) нь 2014 болон 2020 онд Санхүүгийн

сарын 18–нд албан ёсоор хүчингүй болсон<sup>9</sup>. Өмнөх тусгай заавар бүрэн хүчингүй болсноор нэгдлийн хяналтын үүрэг, хүрээ нь одоо JFSA-ын “Guidelines for Supervision” цувралд (Comprehensive Guidelines) нэгтгэгдэн орсон.

Одоогоор санхүүгийн нэгдлүүдийн хяналтыг нэг зөвлөмжөөр бус, салбар тус бүрийн нарийвчилсан журам, заавруудын дагуу хяналт, шалгалт явуулж байна. Олон салбар хамарсан буюу банк, даатгал, үнэт цаас зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг бол “Key matters in examining Liquidity Risk Management at Large Complex Financial Groups” гэсэн стандартыг баримтлан хяналт шалгалтаа хийж байна.

“Comprehensive Guidelines for Supervision of Financial Instruments Business Operators, etc.” (Санхүүгийн хэрэгслийн бизнес эрхлэгчдийг хянах иж бүрэн удирдамж) нь Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA)–аас боловсруулсан баримт бичиг бөгөөд санхүүгийн оролцогчдыг хянах, зохицуулах үндсэн зарчмуудыг тодорхойлдог.

салбарын үнэлгээний хөтөлбөр (FSAP)–өөр дамжуулан холдинг бус санхүүгийн нэгдлийг хянах хуулийн үндэслэлийг боловсруулах, хяналтыг чангатахыг зөвлөсөн<sup>11</sup>. “Санхүүгийн нэгдлийн нэгдсэн хяналтыг хэрэгжүүлэх” – ийг 2017 онд засгийн газрын үндсэн чиглэлд батлагдсан<sup>12</sup>. Санхүүгийн үйлчилгээний

<sup>9</sup> [https://www.fsa.go.jp/en/laws\\_regulations/index.html#Financial\\_Monitoring\\_Policy](https://www.fsa.go.jp/en/laws_regulations/index.html#Financial_Monitoring_Policy)

<sup>10</sup> 송홍선, “금융그룹에 대한 통합감독과 자본규제”, 금융리스크리뷰 제3권 제1호, 2006

<sup>11</sup> IMF, REPUBLIC OF KOREA: financial system stability assessment, March 10, 2020, pp51–52

<sup>12</sup> National task <https://www.evaluation.go.kr/>

хороо (Financial Services Commission)–оос “Санхүүгийн нэгдлүүдэд хяналт тавих загвар стандарт, жишиг дүрмийг 2018 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн<sup>13</sup>. Санхүүгийн нэгдлүүдийн хяналтын тухай хуулийн төслийг 20 дугаар Үндэсний Ассамблейд өргөн барьсан боловч батлагдаагүй бөгөөд

дахин 21–р Үндэсний Ассамблейд 2020 оны 12 дугаар сарын 9–ний өдөр танилцуулж Санхүүгийн конгломератуудын хяналтын тухай хууль (Act on Supervision of Financial Conglomerates)–ийг батлан 2021 оны 6 дугаар сарын 30–ний өдрөөс дагаж мөрдөж байна.

### Хүснэгт 10. Солонгос Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг

	Байгууллага	Үндсэн үүрэг	Харьяалал
1	Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC)	Санхүүгийн бодлогыг боловсруулах, зохицуулалт	Ерөнхий сайд
2	Санхүүгийн хяналтын газар (FSS)	FSC–ийн бодлогыг хэрэгжүүлэх, хяналт шалгалт	FSC
3	Солонгосын Төв банк (BOK)	Мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдал	Бие даасан
4	Хадгаламжийн даатгалын корпорац (KDIC)	Санхүүгийн аюулгүй байдлын сүлжээ	Санхүүгийн хороо
5	Төлөвлөлт, санхүүгийн яам (MOEF)	Санхүүгийн хууль тогтоомж, төсвийн бодлого	Засгийн газар

Санхүүгийн конгломератууд (Financial Conglomerates)–д Санхүүгийн Хяналтын газар (Financial Supervisory Service, FSS) хяналт тавьдаг ба Санхүүгийн үйлчилгээний хорооны удирдамжийн дагуу ажилладаг. Өөрөөр хэлбэл санхүүгийн нэгдлийн хяналтыг Санхүүгийн Хяналтын газар хариуцдаг ба бодлогын, үйл ажиллагааны түвшинд Санхүүгийн үйлчилгээний хороо хариуцдаг. Санхүүгийн хяналтын газар (Financial Supervisory Service, FSS) нь Төв банкнаас бүрэн бие даасан, тусдаа статустай байгууллага ба Санхүүгийн үйлчилгээний хороонд харьяалагддаг.

Санхүүгийн үйлчилгээний хороо нь Ерөнхий сайдын харьяа төрийн байгууллага юм<sup>14</sup>. Энэ нь төрд харьяалагддаг хэлбэр гэдгээрээ бусад өндөр хөгжилтэй орнуудын SSA загвараас ялгаатай<sup>15</sup>.

### Санхүүгийн салбарын гол хуулиуд

- Санхүүгийн конгломератуудын хяналтын тухай хууль (*Act on Supervision of Financial Conglomerates*, 2021.06.30): Санхүүгийн конгломератад гарах санхүүгийн эрсдэлийг үр дүнтэй хянах, зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хэрэглэгчийг хамгаалахад

<sup>13</sup> [www.fsc.go.kr](http://www.fsc.go.kr)

<sup>14</sup> <https://www.law.go.kr/> Act on the Establishment of the Financial Services Commission, etc

<sup>15</sup> 금융감독권의 최적 형태에 관한 고찰, 김재영, 최동범 2021

- чиглэсэн гол хууль.
- Санхүүгийн үйлчилгээний хороог байгуулах тухай хууль (*Act on the Establishment of the Financial Services Commission*): Санхүүгийн бодлого боловсруулах, хяналт хэрэгжүүлэх, зах зээлийн тогтвортой байдлыг хангах эрх зүйн үндэс.

**Гол дүрэм, журам, зохицуулалт:**

- Санхүүгийн конгломератуудад тавих хяналтын загвар стандарт
- “Санхүүгийн нэгдлүүдэд тавих хяналтын загвар стандарт” жишиг дүрэм:

- Санхүүгийн конгломератуудад тавих хяналт шалгалтын журам: Regulations on Supervision of Financial Conglomerates
- Санхүүгийн конгломератуудад тавих хяналт шалгалтын журмын гүйцэтгэх дүрэм: Enforcement Rules of the Financial Conglomerate Supervision Regulations
- Санхүүгийн конгломератуудын хяналтын тухай хуулийг хэрэгжүүлэх тогтоол: (Enforcement Decree of the Act on Supervision of Financial Conglomerate)

**Хүснэгт 11.** Солонгос Улсын Санхүүгийн конгломератуудын хяналтын тухай хууль, 2021

№	Бүлгийн нэр	Тайлбар
1	Ерөнхий дүрэм журам	Хуулийн зорилго, нэр томъёо болон үндсэн ойлголтыг тодорхойлсон хэсэг
2	Санхүүгийн олон талт байгууллагыг тодорхойлох зэрэг	Холбогдох этгээдүүдийн үүрэг, холбогдох этгээдийн хасалт буюу өөрчлөлтийн тухай мөн зохицуулагчийн үүрэг, хариуцлагын талаар заасан байна.
3	Дотоод хяналт ба эрсдэлийн удирдлага	Санхүүгийн нэгдэл дэх дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын систем, хөрөнгийн зохистой түвшин, дотоод хэлцэл болон эрсдэлийн төвлөрөл, эрсдэлийн шилжилт зэрэг өргөн хүрээг хамарсан гол бодлогын чиглэлүүдийг тусгасан.
4	Санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалт	Санхүүгийн нэгдэл дэх хяналт, шалгалт, тогтвортой байдал, эрсдэлийн удирдлага, ил тод байдал, хяналт шалгалт болон мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн гол зарчмуудыг тусгасан.
5	Шийтгэл ба захиргааны арга хэмжээний журам	Хууль зөрчсөн үйлдэлд зохистой арга хэмжээ авах, зөрчлийг арилгуулах, сануулга өгөх болон хориг тавих замаар дахин зөрчил гаргах эрсдэлийг бууруулах явдал юм.

6	Нэмэлт заалтууд	Санхүүгийн группийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, Захиргааны арга хэмжээг ил тод байлгах, Хууль хэрэгжүүлэх ажиллагааг нарийвчлан зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх.
7	Торгууль ба эрүүгийн шийтгэл	Санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг баталгаажуулах, Дотоод мэдээллийг хамгаалах, Хууль зөрчсөн этгээдүүдэд шийтгэл оногдуулах эрх зүйн үндэс бүрдүүлэх.

### Санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын аргачлал:

Санхүүгийн хяналтын газар (FSS) нь санхүүгийн нэгдэл (financial conglomerates)–д хамаарах Банк, даатгал, үнэт цаасны компаниудын охин компанид хяналт тавихаас гадна тусгай зээлийн байгууллага, лизингийн компани, Fintech зэрэг санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

Санхүүгийн нэгдэлд төлөвлөгдсөн шалгалтыг жилд 1–2 удаа (байгууллагын хэмжээ, эрсдэлийн түвшингээс хамаарч) хийдэг ба гэнэтийн шалгалтыг эрсдэл нэмэгдсэн эсхүл зөрчил илэрсэн тохиолдолд, тусгай шалгалтыг Fintech, криптовалюта зэрэг шинэ технологид чиглэсэн салбаруудад хийдэг байна. Давтамж болон хугацааны хувьд томоохон банкнууд болон санхүүгийн нэгдэлд жилд 1–2 удаа, 2–6 долоо хоног үргэлжилнэ. Хяналт шалгалтын үр дүнд зөрчил илэрвэл санхүүгийн нөхөн төлбөр, тусгай зөвшөөрлийг түр хураах эрүүгийн шийтгэл зэрэг арга хэмжээг авч ажилладаг байна<sup>16</sup>. Хяналт шалгалтын тайлан байдлаар бэлтгэж FSS–ийн вэбсайт ([www.fss.or.kr](http://www.fss.or.kr))–д нийтлэгддэг байна.

### Эрсдэлд суурилсан хяналт (Risk-based supervision)

Санхүүгийн зохицуулагч байгууллагаас санхүүгийн группийн хяналтын загварыг шинэчлэх замаар нэгдсэн санхүүгийн группийн эрсдэлийг нэгтгэн үнэлэх, группийн хэмжээнд дотоод хяналтын системийг байгуулж, гол эрсдэлийн хүчин зүйлсийг мэдээлэх зэрэг группийн удирдлагын бүтэцтэй холбоотой эрсдэлийн хяналтын аргачлалыг нэмэгдүүлэх чиглэл баримталж 2013 оноос Базель III стандартыг нэвтрүүлсэн мөн банкнуудын хөрвөх чадварын шаардлага (LCR, NSFR) нэмэгдсэн.

- ICAAP, ORSA зэрэг аргачлал хэрэглэдэг.
- Базель III нэвтрүүлсэн (2013)
- Хөрвөх чадварын үзүүлэлт: LCR, NSFR–ийг харгалздаг.

Ийнхүү санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалтын олон улсын туршлагаас үзэхэд Их Британи, Австрали улс *хосолсон загвар* (Twin Peaks Approach), харин Солонгос, Сингапур улс *нэгдсэн загвар* (Integrated Approach) хэрэгжүүлж байна. Япон улс уламжлалт *институционал загварыг* (Institutional Approach) хадгалж байгаа ч

<sup>16</sup> <https://www.law.go.kr/> Enforcement Rules of the Financial Conglomerate Supervision Regulations

нэгдсэн хяналтын элементүүдийг агуулсан байна. Ихэнх орнууд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлал (risk-based supervision) нэвтрүүлж, макро зохистой

байдлын шинжилгээ болон группийн түвшинд хөрөнгийн үнэлгээ, стресс тест зэрэг интеграцчилсан үнэлгээний арга зүйг ашиглаж байна (Хүснэгт 7).

## Хүснэгт 12. Улс орнуудын харьцуулалт

Улс орнууд	Санхүүгийн нэгдлийн тодорхойлолт	Хяналт хариуцсан байгууллага	Санхүүгийн нэгдлийн оролцогчид	Хяналтын загвар
Их британи	<b>“Санхүүгийн нэгдэл”</b> гэдэг нь банк, хөрөнгө оруулалт, даатгалын үйл ажиллагаа явуулдаг ААН-г нэгтгэсэн, санхүүгийн салбарын олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг группийг хэлнэ. Групп гэдэгт толгой компани, түүний охин болон хамаарал бүхий компаниудыг хамаарна.	Prudential Regulation Authority (PRA), Financial Conduct Authority (FCA)	Банк, даатгал, хөрөнгө оруулалтын сан	Хосолсон хэлбэр / Twin Peak Approach/
Австрали	<b>“Санхүүгийн нэгдэл”</b> Level 3 ангилалд нь конгломерат групп хамаарагдах ба группийн толгой компани нь банк, ердийн даатгалын компани, эсхүл амьдралын даатгалын компани байна. Тус ангилалд ARSA-с зохицуулалттай болон зохицуулалтгүй салбарууд орно.	Australian Prudential Regulation Authority (APRA), Australian Securities and Investments Commission (ASIC)	Толгой компани нь банк, ердийн даатгалын компани, эсхүл амьдралын даатгалын компани	Хосолсон хэлбэр / Twin Peak Approach/
Солонгос	<b>“Санхүүгийн нэгдэл”</b> гэж ижил бизнесийн бүлэгт хамаарах /Зээлийн болон хадгаламжийн үйлчилгээ, Хөрөнгийн зах зээлийн болон санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ, Даатгалын үйлчилгээ/ хоёр буюу түүнээс дээш санхүүгийн байгууллагаас бүрдсэн бүлгийг хэлнэ.	Financial Services Commission (FSC), Financial Supervisory Service (FSS)	Зээлийн болон хадгаламжийн үйлчилгээ, Хөрөнгийн зах зээлийн болон санхүүгийн хөрөнгө оруулалтын үйлчилгээ, Даатгалын үйлчилгээ	Нэгдсэн хэлбэр / Integrated Approach/

Сингапур	<p><b>“Financial holding company”</b> <b>(санхүүгийн холдинг компани):</b> “Санхүүгийн холдинг компани” гэж дараах шаардлагыг хангасан холдинг компанийг хэлнэ: (а) Сингапурт үүсгэн байгуулагдсан банк эсхүл Сингапурт байгуулагдсан, бүртгэгдсэн эсхүл үүсгэн байгуулагдсан даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь дор хаяж нэг охин компани эзэмшдэг байх; (б) Тус охин компани (эсхүл санхүүгийн байгууллагын статустай охин компаниуд нийлсэн байдлаар) нь уг холдинг компанийн нийт хөрөнгө, капитал, өр төлбөр эсхүл орлогын 50 буюу түүнээс дээш хувийг бүрдүүлдэг байх.</p>	Monetary Authority of Singapore (MAS)	Банк, даатгал	Нэгдсэн хэлбэр / Integrated Approach/
Япон	<p><b>Санхүүгийн нэгдэл</b> гэдэг нь банкны үйл ажиллагаа, даатгалын үйл ажиллагаа, болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа зэрэг хоёр буюу түүнээс дээш санхүүгийн салбарт зэрэг үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдүүдийг багтаасан группийг хэлнэ.</p>	Financial Services Agency (JFSA)	Банк, үнэт цаас, даатгал	Институ-цинал хэлбэр / Institutional Approach/

*Эх сурвалж: Судлаачдын боловсруулалт*

### 3.5 МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад 1991 онд Банкны тухай хууль батлагдаж анхны хоёр шатлалт банкны тогтолцоо бий болсноор арилжааны банкнуудын үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд мөн онд Хөрөнгийн бирж байгуулагдаж төрийн өмчийн компаниуд биржээр

дамжуулан хувьчлал хийснээр хөрөнгийн зах зээлийн хөгжил эхэлсэн. Санхүүгийн салбарын зохицуулалтыг Монгол Улсын Төв Банк–Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлдэг.

**Хүснэгт 13.** Монгол Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд, чиг үүрэг

№	Зохицуулагч байгууллага	Чиг үүрэг
1	Монголбанк	Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага бөгөөд арилжааны банкнуудын үйл ажиллагааг хянаж, зохицуулан төлбөрийн системийг хянах үүргийг гүйцэтгэдэг. Монголбанк нь санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлдэг.
2	Санхүүгийн зохицуулах хороо	Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага юм. Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсан 2006 оноос үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо гэсэн 4 санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалан ажиллаж байсан бол нэмэлт өөрчлөлт болон шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулалт нэмэгдэж 2024 онд санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн 11 салбар болсон.

**Санхүүгийн салбарын гол хуулиуд**

- Төв банкны тухай хууль /1996 он/
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль /2002 он/
- Даатгалын тухай хууль /2004 он/
- Банкны тухай хууль /2010 он/
- Хадгаламж зээлийн хоршооны тухай хууль /2011 он/
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль /2011 он/
- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль /2012 он/
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2013 он/
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль /2013 он/
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль /2021он/
- Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль /2022 он/
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль /2022 он/

Монгол Улсад санхүүгийн нэгдэл нь 2010 оны Банкны тухай хуулийн 6.2-д зааснаар банк нь Санхүүгийн зохицуулах хорооны

зөвшөөрөлтэйгөөр санхүүгийн бусад салбар үйл ажиллагаа, үүнд: санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх, итгэлцлийн үйлчилгээ, даатгалын зуучлагч, андеррайтерын үйлчилгээ, кастодиан, факторингийн үйлчилгээ

зэрэг үйл ажиллагааг эрхэлж болохоор хуульчилснаар үүссэн. Санхүүгийн салбарын хуулиудад санхүүгийн нэгдлийн тусгайлсан хууль, журам байхгүй бөгөөд салбар тус бүрийн хууль, журмаар хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн нэгдэл гэдэг нь банк, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэг санхүүгийн салбаруудыг нэгтгэсэн, нэгдсэн удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг цогц бүтэц юм. Энэхүү бүтцийн үүсэл хөгжил, түүхэн хувьсал нь дэлхийн эдийн засгийн хөгжил, санхүүгийн либералчлал, технологийн дэвшил, хууль эрх зүйн өөрчлөлтийн суурь нөхцөлд үндэслэгдэн өргөжиж ирсэн. Тухайлбал, 2007–2009 оны дэлхийн санхүүгийн хямрал нь хэт том, төвөгтэй бүтэц бүхий санхүүгийн нэгдлүүдийн зохицуулалтыг сайжруулах, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагыг ил тод харуулсан. Үүний улмаас санхүүгийн нэгдэлд чиглэсэн хяналт шалгалтын гол зорилго нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Олон улсын туршлагаас харвал санхүүгийн нэгдлийг хянах тогтолцооны бүтэц, хэрэгжүүлэлтийн аргачлал улс орон бүрд харилцан адилгүй боловч нийтлэг зарчим, чиг хандлага ажиглагддаг. Жишээлбэл, Их Британи, Австрали улс “Twin Peaks” загварыг хэрэгжүүлж, зохистой хяналт ба зах зээлийн зохицуулалтыг тусгаарлан гүйцэтгэдэг бол Сингапурт төвлөрсөн зохицуулалтын бүтэц (MAS), Японд салбар тус бүрд чиглэсэн нарийвчилсан удирдамж, БНСУ–д шаталсан бүтэц бүхий нэгдсэн хяналтын тогтолцоо үйлчилдэг. Эдгээр улс

орны хяналтын арга зүйд эрсдэлд суурилсан хандлага давамгайлан хэрэглэгддэг. Мөн Joint Forum, Solvency II зэрэг олон улсын байгууллагуудын боловсруулсан зарчим, удирдамж нь санхүүгийн нэгдлийн бүлгийн түвшний зохицуулалт, эрсдэлийн удирдлагыг сайжруулахад чиглэж, улс орнуудын хяналтын тогтолцооны уялдаа холбоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Монгол Улсад банкны салбарын хяналт шалгалтыг Монголбанк, банкнаас бусад санхүүгийн байгууллагын хяналтыг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна. Гэвч санхүүгийн нэгдэлтэй холбоотой тусгайлсан, цогц эрх зүйн зохицуулалт хараахан бүрдээгүй бөгөөд Компанийн тухай болон Банкны тухай хуульд хэсэгчлэн тусгасан байдалтай байна. Энэ нь нэгдлийн түвшинд эрсдэлийг үнэлэх, тайлагнах, хянах үйл ажиллагаанд институт хоорондын уялдаа, мэдээллийн нэгдмэл байдал, тайлагналын ил тод байдал хангалтгүй байгааг илтгэдэг.

Иймд Монгол Улсад санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын сайн туршлага, зарчмуудыг үе шаттайгаар нутагшуулах шаардлага улам бүр чухал болж байна. Үүнд, хууль эрх зүйн шинэчлэл хийх, санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, мэдээлэл солилцооны механизмыг сайжруулах, компанийн бүртгэлийн ил тод

байдлыг нэмэгдүүлэх, нэгдсэн тайлагналын тогтолцоог бий болгох зэрэг нь хяналтын үр дүнг бодитоор сайжруулах үндэс болно. Түүнчлэн стресс тест, ICAAP, ORSA зэрэг аргачлалуудыг өөрийн орны онцлогт тохируулан нутагшуулах замаар санхүүгийн нэгдлүүдийн эрсдэлийг системийн түвшинд удирдах боломжтой. Иймд санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтын олон улсын зохицуулалт, туршлагад үндэслэн дараах саналыг боловсрууллаа.

- Санхүүгийн нэгдлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн нэгдлийн

оролцогч байгууллагуудын хамрах хүрээг тодорхойлох;

- Тусгайлсан хяналт, шалгалтын тогтолцоог бүрдүүлэн олон улсын “Joint forum”-ын зарчимд суурилан санхүүгийн нэгдэлд зориулсан зайны олон газар дээрх хяналт шалгалтын аргачлалыг боловсруулах;
- Санхүүгийн нэгдэл, түүний охин компанийн бүртгэлийн мэдээллийг нэгтгэх нэгдсэн платформыг байгуулах /Улсын бүртгэлийн газарт бүртгэлтэй/ зэрэг болно.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Anguilla Financial Services Commission. (2017). *Guidelines: Consolidated Supervision (Issued under Section 61 of the Financial Services Commission Act, R.S.A. c.F28)*.
- Accounting Standards Council Singapore. (2023). *Statutory Board Financial Reporting Standard 110: Consolidated Financial Statements*. <https://www.asc.gov.sg>
- AHRP Law Firm. (2024, December 28). *Financial Conglomerate and Financial Holding Company Based on OJK Regulation No. 30/2024*. <https://www.ahrplaw.com/post/financial-conglomerate-and-financial-holding-company-based-on-ojk-reg-30-2024>
- Banking Supervision – European Central Bank. (2024, January). *Guide on reporting of significant risk concentrations and intra-group transactions for financial conglomerates*. European Central Bank.
- Barbosa, Klknio & Rocha, Bruno & Salazar, Fernando. (2014). *Assessing Competition in the Banking Industry: A Multi-Product Approach*. *Journal of Banking & Finance*. 50. 10.1016/j.jbankfin.2014.05.003.
- Basel Committee on Banking Supervision (2010). *Basel III: International Framework for Liquidity Risk Measurement, Standards, and Monitoring*.
- Borsuk, M., & Duryk, A. (2016). *Position of the European Financial Congress on the supplementary supervision of financial conglomerates*. *Bezpieczny Bank (Safe Bank)*, 4(65), 116–144.
- Chien, W. H., & Wang, Y. L. (2024, December). *Overcoming class imbalance in financial supervision: A generative adversarial approach*. arXiv Preprint. <https://arxiv.org/abs/2412.15222>
- Consolidated\_Supervision\_of\_Banks\_and\_Fi.pdf. (n.d.). *Handbook for Regulators and Supervisors on Consolidated Supervision of Banks and Financial Conglomerates*. consolidated-sup14.pdf. (n.d.). *Regulatory Requirements for Consolidated Supervision of Investment Businesses*. document.pdf. (n.d.). *Supplementary Supervision of Financial Conglomerates: European Policy Perspective*.
- European Commission. (2014). *Application of the calculation methods of capital adequacy requirements for financial conglomerates* (Commission Delegated Regulation (EU) No 342/2014, as amended, including by the Technical Standards (Financial Conglomerates) (EU Exit) Instrument 2019). *Official Journal of the European Union*.
- European Commission. (2015). *Definitions and coordinating the supplementary supervision*

of risk concentration and intra-group transactions (Commission Delegated Regulation (EU) 2015/2303, as amended, including by the Technical Standards (Financial Conglomerates) (EU Exit) Instrument 2019, Annex B, and the PRA Technical Standards (Consequential Amendments) (EU Exit) Instrument 2020). Official Journal of the European Union.

- Federal Reserve Board. (2024, November). *Supervision and Regulation Report*. <https://www.federalreserve.gov/publications/2024-november-supervision-and-regulation-report.htm>
- Gramm–Leach–Bliley Act (1999), United States Congress.
- Group–Wide\_Consolidated\_Supervision\_in\_Bank\_and\_Financial\_Groups.pdf. (n.d.). *Group–Wide Risk Assessment in Bank and Financial Conglomerates*.
- Hutton, Georgina, et al. (2022). *Financial Services: Contribution to the UK Economy*. Parliament. [uk. researchbriefings.files.parliament.uk/documents/SN06193/SN06193.pdf](http://researchbriefings.files.parliament.uk/documents/SN06193/SN06193.pdf).
- IFRS Foundation. (2022). *IFRS 10 Consolidated Financial Statements: Basis for Conclusions* (January 2022) [PDF file]. IFRS Foundation. (Original work published 2011 [for IFRS 10], updated 2022.)
- Prudential Regulation Authority. (2004). *Financial conglomerates (PRA Rules, Chapter 12)*. In *The Financial Conglomerates and Other Financial Groups Regulations 2004*. UK Legislation.
- RegulatoryPolicy–ConsolidatedSupervisionNov2023\_1700579536.pdf. (n.d.). *Group–Wide Supervision Requirements under Cayman Islands Regulatory Policy*.
- Reuters. (2025, April 8). *FINMA to be more active in future, says Swiss regulator after Credit Suisse crisis*. <https://www.reuters.com/business/finance/finma-will-be-more-active-future-swiss-regulator-says-2025-04-08>
- Rysin, V., Galenko, O., Duchynska, N., et al. (2021). *Financial Convergence as a Mechanism for Modifying Sectors of the Global Financial Services Market*. Universal Journal of Accounting and Finance.
- SB–FRS\_110\_(2023).pdf. (n.d.). *Singapore Standard SB–FRS 110: Consolidated Financial Statements*.
- Scott, D. H. (1995). *Regulation and Supervision of Financial Conglomerates*. World Bank
- Toronto Centre. (2016). *Group–Wide Consolidated Supervision in Bank and Financial Groups*.
- World Bank. (1995). *Regulation and Supervision of Financial Conglomerates* (FPD Note No. 36). Washington, D.C.: The World Bank.

